



1.12 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН БОЛОН БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Компанийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг 9011119040 улсын бүртгэлийн дугаар, 19 тоот хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ бүхий "Үндэсний Реалти" ХХК-аар хөрөнгийн үнэлгээг 2011/02/28-ны байдлаар гүйцэтгүүлсэн.

Хөрөнгийн үнэлгээний нэгтгэл

Компанийн Дорноговь аймгийн Замын-Үүд суман дах ачаа тээврийн цогцолборын хөрөнгийг Олон Улсын Стандарт Үнэлгээний дагуу хүлээн зөвшөөрөгдсөн аргууд болох орлогын хандлагын арга, зарлагын хандлагын арга, зах зээлийн хандлагын аргуудыг ашиглан хөрөнгийн төрөл тус бүр дээр өнөөгийн үнэлгээг тодорхойлж гаргасан байна.

Цогцолборын хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн өнөөгийн үнэлгээг 2011/02/28 өдрийн байдлаар нийт 4,674,800,600.00 төгрөгөөр тогтоосныг товчоолон доорх хүснэгтэд үзүүллээ.

Хөрөнгийн нэр	Үнэлгээ /мян.төг/
1 Барилга	1,698,800.0
2 Байгууламж	1,946,200.0
3 Машин тоног төхөөрөмж	160,800.0
4 Тавилга, эд хогшил	27,845.6
5 Тээврийн хэрэгсэл	17,000.0
6 Компьютер дагалдах хэрэгсэл	1,155.0
Дүн	3,851,800.6
7 Газар эзэмших эрэх	823,000.0
Нийт дүн	4,674,800.6

Хүснэгт 12 Хөрөнгийн үнэлгээний нэгтгэл


Бизнесийн үнэлгээний нэгтгэл

"Э-Транс Ложистикс" ХХК нь шинээр үнэт цаас гарган олон нийтэд санал болгох болсонтой холбоотойгоор "Үндэсний Реалти" ХХК нь тус компанийн бизнесийн үнэлгээ буюу нэгж хувьцааны зах зээлийн өнөөгийн үнэлгээг 2011/02/28-ны өдрөөр тасалбар болгон Олон улсын үнэлгээний стандарт, арга хандлага, аргачлалын дагуу бие даасан хараат бус байдалд хийж гүйцэтгэсэн.

Бизнесийн үнэлгээний тайланг дараах хандлагуудаар үнэлсэн.

- Өртгийн хандлагын арга
- Орлого капиталжуулалтын хандлага
- Зах зээлийн харьцуулалтын хандлага

Бизнесийн үнэлгээний зорилго зориулалтаас хамаарч үнэлгээний арга сонголт, үр дүн, давуу болон дутагдалтай талуудыг шинжилж үзээд ирээдүйн цэвэр мөнгөн гүйлгээг хорогдуулан тооцох аргаар хийсэн бизнесийн үнэлгээнд 60%-ийн ач холбогдол өгсөн. Өртгийн хандлагын аргаар үнэлгээг хийхдээ тухайн бизнесийн үйл ажиллагаа нь өөрчлөн зохион байгуулагдах, татан буугдахгүй цаашид



1.12 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН БОЛОН БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

үргэлжлэх учир цэвэр хөрөнгийн аргаар хийсэн үнэлгээнд 40%-ийн ач холбогдлыг тус тус өгч бизнесийн үнэлгээг хийсэн байна.

Үнэлгээний арга	Үнэлгээ /мян.төг/	Ач холбогдол	Тооцсон дүн /мян.төг/
1 Цэвэр хөрөнгийн үлдэгдлийн арга	4,677,154.8	40%	1,870,861.9
2 ЦМГ хорогдуулан тооцох арга	6,292,084.6	60%	3,775,250.8
3 Зах зээлийн харьцуулалтын арга			
Дүн	10,969,239.4	100%	5,646,112.7

Хүснэгт 13 Бизнесийн үнэлгээний нэгтгэл

Бизнесийн үнэлгээний ажил, тооцоо, судалгаа, шинжилгээний дүнд гарсан үр дүнг үнэт цаас гаргагчийн 100 хувийн өмчийн бизнесийн өнөөгийн үнэ цэнийг дунджаар 5,646,112.7 мянган төгрөгөөр тооцсон.

Бизнесийн үнэлгээ хийсэн 2011/02/28 өдрөөр үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн капиталын бүрдүүлж буй 38,500,000 ширхэг энгийн хувьцааны нэгжийн зах зээлийн үнийг 147 төгрөгөөр тооцож гаргасан байна.

